

ХОРИХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛ



Г.ХОСБАЯР

Дотоод хэргийн их сургуулийн
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн
Харуул хамгаалалт, гүйцэтгэх ажлын тэнхимийн ахлах
багш, хошууч

Товч агуулга: Илтгэлд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын түүхэн хөгжил, хорих ял эдлүүлэх ажиллагааны уламжлал, эрх зүйн шинэчлэлийн талаар үечлэн авч үзэж, судлаачийн зарим дүгнэлт, саналыг илэрхийлсэн.

Abstract: The researcher identifies needs, rationales and issues with respect to the use firearms, special weapons and force by officers from the Court Decision Execution Authority and government authorities with special mandates and takes into account challenges faced.

Түлхүүр үг: Хорих ял эдлүүлэх ажиллагаа, түүхэн уламжлал, эрх зүйн шинэчлэл.

Key words: Imprisonment processes and historical tradition, and transformation of legal framework.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага 1921 оны 07 дугаар сарын 10-нд Шүүх яамны ерөнхий хэлтсийн харьяанд “Гяндан салаа” нэртэйгээ байгуулагдсанаас хойш эдүүгээ 100 жил болж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага байгуулагдсан цагаасаа эхлэн шүүхийн шийдвэрээр төрийн онцгой албадлагыг хэрэгжүүлж, цагдан хорих, хорих ял шийтгүүлсэн этгээдийн хорих ялыг эдлүүлэх, нийгэмшүүлэх, зан үйлд нөлөөллийн арга хэмжээ авах, хөдөлмөрлүүлэх, хөдөлмөрийн чиг баримжаа олгох, ард иргэдийнхээ амгалан тайван байдлыг хамгаалах, хоригдлуудын дундаас гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэн, захиргаа, зөрчлийн болон эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хуульд заасан үндэслэл журмын дагуу олон улсын гэрээ конвенцид заасны дагуу хүний эрх, эрх чөлөөг хамгаалах,

хууль дээдлэх зарчмын хүрээнд амжилттай зохион байгуулсаар ирсэн түүхэн уламжлалтай.

Монгол улсын эрх зүйн хөгжлийн түүхэнд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа тэр дундаа хорих ял эдлүүлэх ажиллагааны түүхэн уламжлалын талаар харьцангуй бага судлагдсан боловч сүүлийн үед түүхэн хууль цаазын судлал эрчимтэй хөгжиж байгаагаас тухай ажиллагааны уламжлалыг танин мэдэх боломжийг олгож байна.

Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг тодорхой хугацаагаар хорьж гэм буруутайг нь тогтоон, тохирсон ял оногдуулж ирсэн нь баттай боловч ХХ зуун хүртэл ямар нөхцөлд, хэрхэн хорьж ирсэн талаар түүхийн баримт материал хомс байна.

Монгол Улсын төр гэм буруутай этгээдийн хэргийг шүүн хэлэлцэхдээ төрт ёсоо дээдлэн ялд унагаж, түүний ялыг эдлүүлж ирсэн өнө эртний түүхтэй билээ. МЭӨ VII-IX зуунд хүчирхэгжин хөгжиж, Кидан улсын үед буюу 745 онд “газар гяндан” гэгчийг байгуулж ялт хүнийг хорьдог байжээ.¹

Академич С.Нарангэрэл Монгол Улсад орчин үеийн эрх зүй үүсэж хөгжсөн түүхэн үеийг Монголчуудын нэгдсэн нийт үндэсний эрх зүйн тогтолцоо төлөвшин бүрэлдэх үе, энэ нь монгол угсаатны улс гүрэн бий болсноос Чингис хааны Их засаг хууль батлагдсан үе, Монгол-Ойрадын хууль, Халх журам, Гадаад Монголын хууль зүйлийн бичиг зэрэг эрх зүйн хоёр дахь төрөлжүүлэлт хийгдсэн үе, Орчин үеийн эрх зүйн тогтолцоог бүрэлдүүлэн хөгжүүлсэн үе хэмээн гурван үе шаттайгаар үнэлэн авч үзсэн² байдаг.

Харин доктор, дэд профессор Б.Алтангэрэл нь Монгол Улын төр, эрх зүйн түүхэн уламжлалын үечлэлийг тухайн үеийн төр, нийгмийн тогтолцоо, эрх зүйн зохицуулалтын байдлаас хамааруулан эрх зүйн хөгжлийг хүн төрөлтний болон Монголын түүхийн ерөнхий зарчим, онцлогтой хамааруулан, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хорих болон тухайн үеийн хорих ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын онцлогийг харгалзан дараах байдлаар үечлэн авч үзсэн байна. Үүнд:

1. Эртний үеийн хорих ажиллагаа /МЭӨ III-МЭ XIII зуун/
2. Дунд зууны үеийн хорих ажиллагаа /XIII-XVIII зуун/
3. Манжийн ноёрхлын үеийн хорих ажиллагаа /XVIII-XX зуун хүртэл/

¹ Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан. Монголын төр, эрх зүйн түүх. УБ хот, 1999, 173 дахь тал

² С.Нарангэрэл. Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. УБ хот, 2001 он, 99 дэх тал

4. Богд хаант улсын үеийн хорих ажиллагаа
5. Ардын хувьсгалын дараах үеийн хорих ажиллагаа /1921-1990 он/
6. Ардчилсан хувьсгалын дараах үеийн хорих ял эдлүүлэх ажиллагаа /1990 оноос өнөөг хүртэл/ гэж тус тус ангилжээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эрх зүйн хөгжил, эрүүгийн шийдвэр гүйцэтгэлийн бодлогын хувьсал, өөрчлөлтийг сүүлийн 90 гаруй жилийн түүхийн баримтуудад тулгуурлан хөгжлийн 3 шатанд хуваан авч үзэж болно гэж судлаачийн зүгээс үзэж байна. Энэ нь:

1. Хамжилгат ёсны буюу феодалын үеийн бурангуй үзэл суртал, хэв маягийг халж дэлхийн гүрнүүдийн дэвшилтэд бодлого, арга хэлбэрийг эх үндсээ болгосон үе шат. Үүнд:

- Ардын түр Засгийн газраас гяндан хорооны газрын талаар авч хэрэгжүүлсэн хувьсгалт арга хэмжээний эхнийх нь хаант Монгол Улсын үеийн хуучин гянданг устгаж шинэчилсэн,

- Ардын Засгийн газраас 1921 онд Цээжидийн Гүрсэдээр удирдуулсан комисс томилж “Нийслэл хүрээний их гяндан”, “Их шавийн гяндан”, “Баруун хүрээний гяндан” зэргийг шалгаж, тэдгээрт хоригдож байсан иргэдийг сулласан,

- 1924 оны 11 дүгээр сард хуралдсан Улсын Анхдугаар Их Хурлын тогтоолын Шүүх яамны хэсэгт “Их гяндан ба улсын доторхи олон албан газруудын байдлыг цөм Европын байдалд нийцүүлэх, аливаа ялтан, хэрэгтний бие махбодид харшгүй, зохих гяндангуудыг шинэчлэн байгуулах, ялтнуудыг үйлвэрт зүтгүүлэх, сурган хүмүүжүүлэх ажлыг Шүүх яаманд даалгасан,

- Засгийн газрын 13 дугаар хурлаар Улсын төв гяндангийн шинэ барилга бариулах тухай хэлэлцээд энэ зардалд Сангийн яамнаас 7500 лан мөнгө гаргахаар шийдвэрлэсэн,

- 1924 оны 11 дүгээр сард хуралдсан Улсын Анхдугаар Их Хурал, мөн онд хуралдсан Монгол Ардын Намын III их хурлаас хувьсгалт Монгол Улсын хорих ял эдлүүлэх байгууллагын практик үйл ажиллагаа, эрх зүйн зохицуулалтын үндсэн чиглэл, зарчмыг тодорхойлж өгсөн. Тухайлбал: Монгол Ардын Намын III их хурлын тогтоолд “Гянданаа хоригдож буй хэрэгтэн ардыг үйлдвэрт сургах, сургаж гэгээрүүлэх, аливаа шүүхийн тогтоолгүйгээр хэнийг ч хорихгүй байх, гяндан хорооны байдал нэн муу байгааг даруй сайжруулах, насанд хүрээгүй хөвгүүд, охид хэрэгт холбогдох

аваас гянданаа хорихгүйгээр гэгээрүүлэх, аливаа хэрэгтэн ардын дотроос хүн төлөв, засрах байдалтайг нь гяндаа хорихгүйгээр үйлдвэр хийлгэвэл зохих” зэргийг онцлон заасан, мөн Засгийн газрын 1925 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 12 дугаар хурлаас “Их гянданг сайжруулах тухай” 16 зүйлт дүрмийг баталсан нь орчин цагийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын цаашдын хөгжилд чухлаар нөлөөлсөн гэж үзэх бүрэн үндэслэлтэй.

2. ЗХУ-ын Эрүүгийн шийдвэр гүйцэтгэлийн бодлого, ангич үзэл сурталыг нутагшуулсан үе шат. Үүнд:

- Шорон-гяндангаас хүмүүжүүлэх байгууллагад шилжих онол-үзэл баримтлалын хүрээнд хорих ял эдлүүлэх байгууллагын нэр, төрөл, дэглэм өөрчлөгдсөн бөгөөд 1921 онд байгуулагдсан гяндан салааг 1930 оноос эхлэн Засан сайжруулах газар гэж, мөн ялтныг харж хамгаалах албаны хүмүүсийг хуяг гэж нэрлэж байсныг харгалзагч гэж нэрлэхээр, 1940 оноос Дотоод явдлын яамны Засан сайжруулах газрыг Засан хүмүүжүүлэх үйлдвэрийн лагериуд ба хорих ангиудыг удирдах газар /ЗХҮЛ-ХАУГ/ болгон өргөтгөн зохион байгуулжээ. Харин улс орны хөгжлийн цаг үеийн онцлог, нийгэм-эдийн засгийн байдлаас шалтгаалан мөн ял эдлэгсдийн тоо буурах болсноос шалтгаалан Засан хүмүүжүүлэх үйлдвэрийн лагериуд ба хорих ангиудыг удирдах газар /ЗХҮЛ-ХАУГ/-ын үйл ажиллагааг багасган цомхотгож, 1956 оноос Цэрэг ба Нийгмийг Аюулаас Хамгаалах Яамны Засан хүмүүжүүлэх ерөнхий хэлтэс, 1960-аад оноос хорих байгууллагын үйлдвэрлэлийн чиглэл, ял эдлэгсдийг хөдөлмөрийн үр нөлөөгөөр хүмүүжүүлэх ажил нэмэгдэж, улсаас тодорхой хэмжээний үйлдвэрлэлийн төлөвлөгөө өгөгддөг болсонтой холбогдуулан Засан хүмүүжүүлэх ерөнхий хэлтсийг 1963 оноос Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагуудыг удирдах газар болгон өргөтгөн зохион байгуулсан. Засан хүмүүжүүлэх байгууллагуудыг удирдах газрыг 1981 оноос НАХЯ-ны Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагуудыг удирдах газар хэмээн нэрлэх болсон. 1985 онд Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын харьяалал Цагдаагийн байгууллагад шилжсэн тогтолцоог 1991 онд өөрчлөн Монгол Улсын Хууль зүйн яаманд шилжүүлж Хорих байгууллагуудыг удирдах газар болгон тус тус өөрчилсээ.

- Эрүүгийн хариуцлагын зорилго, ялын зорилгыг ялтныг засан хүмүүжүүлэх, дахин хүмүүжүүлэх гэж тодорхойлж, дээрх зорилгыг хангах үндсэн аргыг ял эдлүүлэх дэглэм, нийгэм, олон нийтэд тустай хөдөлмөр,

улс төр хүмүүжлийн ажил, ерөнхий боловсрол, мэргэжил олгох сургалт хэмээн хуульчлан хэрэгжүүлсэн.

- Хорих, нутаг зааж суулгах, уг нутгаас зайлуулах, засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг эдлүүлэх ажиллагаанд ялтныг зайлшгүй хөдөлмөрт хамруулах бодлого баримталсан

- Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагыг тогтвортой ажлын байраар хангаж, улмаар түүнийг улс ардын аж ахуйн зорилт, улсын аж үйлдвэрийн төлөвлөгөөг биелүүлэх нэг байгууллага болгон хандах болсон. Тухайн үеийн удирдах дээд байгууллага, нам засгаас Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагад өгөх үйлдвэрлэлийн төлөвлөгөө жилээс жилд өсөн нэмэгдэж, 1964 онд 30 сая, 1974 онд 98.5 сая, 1984 онд 130 сая... 4 дүгээр таван жилийн 188.2 сая төгрөгийн төлөвлөгөөг 124.7 хувиар, 5 дугаар 5 жилд /1970-1975/ ЗХБУГ-т улсаас өгсөн 383.6 сая төгрөгийн үйлдвэрийн төлөвлөгөөг 126.6 хувиар биелүүлж...76.4 сая төгрөгийн ашигтай ажиллаж байжээ.

- Ялтны орон байр, ахуй хангалт, эмнэлгийн тусламж, үйлчилгээг үе шаттайгаар сайжруулах бодлогыг баримталсан

- Ялтныг засан хүмүүжүүлэх, дахин хүмүүжүүлэхэд болон ял эдлүүлэх байгууллагын үйл ажиллагаанд тавих олон нийтийн байгууллагын оролцоо, хувь хэмжээг нэмэгдүүлэх, үр нөлөөг дээшлүүлэх³ зэргийг энэ үе шатанд хамааруулж болно.

3. Ардчилсан нийгмийн үнэт зүйлс, хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах олон улсын чиг хандлагыг баримжаалсан хууль, эрх зүйн хэм хэмжээг мөрдөж буй үе шат гэж тус тус ангилан авч үзэж болно. Энэ үе шатанд:

- Олон улсын гэрээ, конвенц болон ардчилсан нийгмийн үнэт зүйлсэд тулгуурласан 1992 оны Үндсэн хуулийн агуулга, үйлчлэлд нийцүүлсэн 1993 оны “Хорих байгууллагын болон хорих ял эдлүүлэх тухай хууль”, 1994 оны “Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны тухай хууль”, 1996 онд “Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хууль”, 2002 оны “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”, 2017 оны “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-иуд болон түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн бусад актуудыг баталж мөрдсөн,

³ Н.Гантулга. Монгол Улсын Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй, УБ хот, 2019 он, 41 дэх тал

- Шинээр батлагдсан хуулиудтай уялдан байгууллагын үндсэн чиг үүрэг, бүтэц, хорих ял эдлүүлэх дэглэм, зэрэглэл, хоригдлын эрх, алба хаагчийн эрх зүйн баталгааг хангасан,

- Хорих ял эдлүүлэх ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг дээдлэн, зөвхөн хуульд заасан үндэслэл журмын дагуу ялтны хоригдлын эрхийг хязгаарлах,

- ШШГБ-ын үндсэн чиглэлд иргэний хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэрийг биелүүлэх чиг үүрэг бүхий бүтцийн нэгж байгуулагдаж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг орон даяар зохион байгуулах, биелэлтийг хангах талаар албадлагын арга хэмжээ авах болсон,

- Ялын тогтолцоонд хорихоос өөр төрлийн ялын гүйцэтгэх үүрэг нэмэгдсэнтэй холбогдон энэ ялын үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэсэн агуулга, зохион байгуулалтыг ШШГБ-ын тогтолцоонд бий болгож, ялтан ялыг сайн дураараа биелүүлэх, ялтны хууль ёсны зан үйлийг бүх талаар дэмжиж урамшуулах, ял гарцаагүй хэрэгжих механизмыг бүрдүүлсэн,

- Хоригдлын бусдад учруулсан гэм хорын хохирлыг барагдуулах, хоригдлыг ажлын байраар хангах, тэдэнд мэргэжлийн чиг баримжаа олгох, ажлын байраар хангах, хөдөлмөр болон хууль ёсны зан үйлээр дамжуулан урамшуулал хүртэх, хорих ял эдлэх, эдлүүлэх орчин нөхцөл, хангамж баталгааг сайжруулж, хорих ангийн байрлалд хувийн өмчийн болон хорих байгууллагатай хамтарсан, хувь нийлүүлсэн үйлдвэрийн газар ажиллуулах боломж бүрдсэн,

- Хоригдол, хоригдсон этгээдэд үзүүлэх нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээ, түүнчлэн тэдэнд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж олон улсын жишигт хүрсэн эрх зүйн таатай орчныг бүрдснийг тус тус дурьдаж болно.

Монгол Улсын Их Хурлын 2012 оны 37 дугаар тогтоолоор батлагдсан Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Эрүүгийн болон иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг ялгавартай зохион байгуулах⁴”, “Ялын бодлогыг оновчтой, үр нөлөөтэй, олон сонголттой болгох” зорилтыг дэвшүүлж, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 193 дугаар тогтоолоор “Хорих ангийн төрөл, дэглэмийг нээлттэй болон хаалттай тогтолцоонд шилжүүлэх хөтөлбөр”-ийг тус тус баталсан.

⁴ Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр

Монгол Улсын Засгийн газраас дэвшүүлсэн зорилт, эрх зүйн шинэчлэлийн бодлогын хүрээнд Улсын Их Хурал 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр Эрүүгийн хуулийг баталж, ялын төрөл, хэлбэрийг шинээр тодорхойлж хорих ялыг нээлттэй, хаалттай хорих байгууллагад, өсвөр насны хүнд оногдуулсан хорих ялыг сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад эдлүүлэхээр хуульчилсан.

Хорих ял, сэжигтнийг баривчлах, яллагдагчийг цагдан хорих шүүхийн шийдвэрийг хорих байгууллага, хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг, аймаг, нийслэлийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн шийдвэр гүйцэтгэгч хэрэгжүүлэх болсон. Хорих байгууллага нь нээлттэй, хаалттай хорих анги, сургалт хүмүүжлийн тусгай байгууллага, цагдан хорих төв, байр, нэгдсэн болон төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг, мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төвөөс бүрдэнэ⁵ гэж хуульчлан заасан,

Хорих ялыг ялгамжтай эдлүүлэх зарчмын хүрээнд нээлттэй хорих анги нь энгийн болон тусгай зэрэглэлд⁶, хаалттай хорих анги энгийн, тусгай зэрэглэл болон тусгай нэгжид хуваагдсан⁷. Хорих ял эдлүүлэх ажиллагааг олон улсын жишигт нийцсэн нөхцөлд хүргэх, мөн олон улсын гэрээ, конвенцийн хэм хэмжээг дотоодын хууль тогтоомжид нийцүүлэх, ялын зорилгыг хангахад чиглэсэн эрх зүйн зохицуулалтын механизмыг бүрдүүлэх ажиллагаа нь ШШГБ-ын эрх зүйн хөгжлийн уламжлал, шинэчлэлтэй холбогдоно.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйд хамаарах хууль тогтоомжийн уламжлал, хөгжлийн тоймыг Ардын хувьсгал ялсан 1921 оноос хураангуйлан авч үзвэл:

1. 1931 оны “Монгол Ард Улсын дотор аливаа хэрэгтэн ялтанг засан сайжруулах ажлын тухай хууль”,
2. 1966 оны “БНМАУ-ын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн тухай хууль”,
3. 1981 оны “БНМАУ-ын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн тухай хууль”,

⁵ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 195.1, Төрийн мэдээлэл сэтгүүл, 2017 он, №24

⁶ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 198, Төрийн мэдээлэл сэтгүүл, 2017 он, №24

⁷ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 195.3, Төрийн мэдээлэл сэтгүүл, 2017 он, №24

4. 1993 оны “Хорих байгууллагын болон хорих ял эдлүүлэх тухай хууль”,
5. 1994 оны “Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны тухай хууль”,
6. 1995 оны “Хорихосс өөр төрлийн ял эдлүүлэх болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ хэрэгжүүлэх тухай хууль”,
7. 1996 оны “Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хууль”
8. 1999 оны “Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль”,
9. 2000 оны “Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хууль”,
10. 2002 он, 2017 оны “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль” зэрэг хуулиуд, мөн хугацаанд дээд байгууллагаас гаргасан олон эрх зүйн актууд хамаарна.

Монгол Улсын хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт 1992-1993 онд хуульчлагдаж эхэлсэн бол, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх, ялангуяа Хорих ял эдлүүлэх байгууллагын үйл ажиллагаа 1931 оноос хуульчлагдан хэрэгжиж ирсэн онцлогтой⁸.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хөгжлийн стратеги, байгууллагын эрхэм зорилго, зорилтод тусгагдсан гол заалт нь хорих ял эдлүүлэх ажиллагааг олон улсын жишигт хүргэнэ гэж заасан нь зөвхөн хоригдлын байр, ял эдлүүлэх орчин нөхцөл, ахуйн хангалтыг гадаадын зарим орнуудтай харьцуулах, жишихээр хязгаарлагдахгүй бөгөөд олон улсын хамтын нийгэмлэгээс хорих ял эдлүүлэх чиглэлээр батлан гаргасан олон улсын гэрээ, конвенцид нэгдэн орж, тухайн баримт бичгийн үзэл баримтлалыг нутагшуулах, алба хаагчийг мэргэшүүлж сургах, тэдний эрх зүйн байдлыг хангах, баталгаатай эдлүүлэхэд оршино.

Хорих ял эдлүүлэх ажиллагааны хөгжлийг түүхэн эх сурвалж, эрх зүйн актуудын үйлчлэл, хэрэгжилтэд дүн шинжилгээ явуулж, төрөөс эрүүгийн ялын бодлогод ялын оновчтой төрөл, тогтолцоо, ял эдлүүлэх орчин нөхцөлийг боловсронгуй болгох чухал юм.

⁸ А.Лхагва, Д.Даваа-Очир. Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын түүхэн замнал, УБ хот, 2011 он, 502 дахь тал.

Дүгнэлт-Санал

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын түүхэн хөгжил, эрх зүй зохицуулалтын уламжлал, шинэчлэл нь онолын болон практикийн чухал ач холбогдол бүхий судлагдахуун хэсэг юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал, эрдэм шинжилгээ, судалгаа, сургалтын ажил 1970 оны дунд үеэс бие даасан хэлбэрээр зохион байгуулагдаж, өнгөрсөн 40 гаруй жилийн хугацаанд бодитой амжилтад хүрсэн ба цаашид улам нарийвчлан судлах хэрэгцээ шаардлага үүсч байгаа бөгөөд энэ нь тодорхой эрдэмтэн, судлаачдын судалгааны бүтээл, ном сурах бичгээр хязгаарлагдахгүй.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь өнгөрсөн 100 жилийн хугацаанд шинэ тогтолцоо, эрх зүйн зохицуулалт, хорих ял эдлүүлэх орчин нөхцөл, дэглэм зэрэглэл, хоригдол, хоригдогч болон алба хаагчийн эрх зүйн байдал түүнчлэн үйл ажиллагааны чиглэлд тодорхой өөрчлөлтүүд тухайн үеийн улс төр, нийгэм, эдийн засгийн байдлаас хамааран өөрчлөгдөж байжээ.

Цаашид Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эрх зүйн зохицуулалт, бүтэц тогтолцоо, эрх зүйн зохицуулалт, үйл ажиллагааны үндсэн чиглэлд эрх зүйн шинэчлэлтэй уялдуулан хийгдэх чиглэл ч тодорхой боллоо.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын түүхэн уламжлал, эрх зүйн шинэчлэлтэй холбоотой дараах зохицуулалт, практикийг бий болгохыг санал болгож байна. Энэ нь:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын түүхэн уламжлал, шинэчлэл, хорих ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн хөгжлийг илүү нарийвчлан судлах,
2. Судалгааны ажилд практик болон судалгааны байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх, алба хаагч, багш, судалгааны ажилтны оролцоог нэмэгдүүлэх, урамшуулах,
3. Судалгааны тайлан, материалыг сургалт судалгааны эргэлтэд оруулах зэрэг болно.